

**Манжаа**  
\ хөрөг \

Манжааг гэнэт саналаа. Хүүхдээс өндөргүй, өөртөө томдсон ээтэн монгол гутал, элбэгдсэн дээлтэй Манжаа минь. Түүнийг өдий олон жилийн хойно сэтгэлийн олон гуу жалга нэгжин дурсах юм гэж санасан ч биш дээ. Манжаагийн уг нэр нь Манал. Гэвч миний л мэдэхийн толгойтой болгон Манжаа Манжаа гэгцгээдэг байлаа. Навсар жаахан Манжаа элбэгдсэн дээл, томдсон гуталтайгаа зогсож байх нь модоор зорсон монгол шатрын ноёнорхуу бас ч хэвлүүн. Дээр нь нэг онцлог түүнд байжээ, одоо бодоход. Хүн бүр тэр үед "бидний монгол эзэн Чингисийн үеэс эхлээд..." гэж хэлж байсангүй.

Манжаа л хэлнэ. Айл саахалтын адууны хөвгүүд, хурга тугалаас хэтрээгүй муусайн дудрай хүүхдийг ч залуу юм, бага юм гэж чамлахгүй, өглөөний адуу оройтуулах, хурга нийлүүлэх зэрэгт "манай монгол эзэн Чингисийн үеэс малаа малласаар ирсэн байтал чи яасан..." энэ тэр гэх мэтээр загнаж дуулдана. Айл саахалтынхан Манжааг Манжаа гэвч хүндэлж хүлцээд байгаа биш дооглож марзагнан ахайлж гуайлаад байсан даг аа.

-Сайн уу Манжаа, таны наад нүүр, ам чинь яачихаа вэ. Саарал ухнаасаа дээргүй харагдаж байх чинь вэ. Очиж, очиж ийм өмхий тос нүүрэндээ нялаад байхдаа яадаг юм бэ та гэнэ.

Манжаа аминдаа арга бодсон юм байх, хамууны тос хамаг нүүрээрээ түрхээд гоо сайхны тос хэрэглэсэн хүүхнүүдээс дутуугүй сэтгэл дүүрэн муу мод толгойгоо сорж хөхөж сууна. Уг нь Манжаа мод толгой дээрээ буухаар эр бишсэн дээ. Сайхан гаанстай байсан хүн. Маналын цагаан гэж нарийхан цагаан соруултай, эрчүүл үнэ хаяж авах гэхээр зардаггүй, эцгээс үлдсэн юм ч гэдэггүй бүр өвөг дээдсийн юм үрж болохгүй гэсээр байгаад сумын төвөөс хойш айлын найранд очоод буцахдаа Төхөмийн дэрсэнд хаяад гаансгүй болж амарсан хүн.

-Манжаа гадаа зун болсон шүү дээ, мэдсэн үү? Үстэй дээлээ тайлаач, айраг залиглаад байх, үстэй дээлээ пөөнийлгөчихөөд хаашаа амьтан бэ гэж охид хүүхнүүд жиг жиг хийнэ. Ингэж л байдаг юм, юугаа өмсөнө та нарт ямар пад байна гэсэн мэт Манжаа чихгүй толгой царайлан өөрийнхөө гоё, нимгэхэн, цэнхэр шаазан хуланд айраг хийлгээд нүд анин цөлж хэрхэндээ хөөрхөн хөлчүү буузайн сууна. Манжаа нээрээ л буузгар хүн юм. Хонины муухан мөлжсөн тойгорхуу хоовон толгойтой, үсээ ямагт тонгоргоор үргээлгэж, нэг талын шазуураа зууж ярих тул эзэгийг үмхчихсэн юм шиг нэг хацар нь бумбайж буузгар дээрээ буузайгаад, ярих гэж удаан зуурч өгнө дөө. Тэгж явж "Зуураа" хочтой болсон юм.

**1.Эхийн сэдвийг тодорхойлоорой\ 2 оноо\**  
.....  
.....  
.....

**2. Манжааг ажилсаг, малч хүн болохыг илэрхийлсэн өгүүлбэрийг бичээрэй. \ 2 оноо \**  
.....  
.....  
.....

**3." Ингэж л байдаг юм, юугаа өмсөнө та нарт ямар пад байна гэсэн мэт Манжаа чихгүй толгой царайлан өөрийнхөө гоё, нимгэхэн, цэнхэр шаазан хуланд айраг хийлгээд нүд анин цөлж хэрхэндээ хөөрхөн хөлчүү буузайн сууна." гэсэн хэсэгт зохиогчийн ашигласан содин содон үг хэллэг аль нь вэ? \ 2 оноо \**

**4." Хөрш айлын хүү нь маргааш иржээ" гэсэн өгүүлбэрийг зөв засан найруулж бичээрэй.\2 оноо \**  
.....  
.....  
.....

**5.Хоол+л гэдэгтэй адил дүрэмтэй бичигддэг үг 2-ыг бичээрэй. \ 2 оноо \**

.....  
.....

**6. Зохиолын гол санааг бичээрэй. \ 5 оноо \**

Зохиол	Гол санаа
1.Д.Цоодол "Харамчийнхны дууль"	
2.Л.Түдэв "Эрээн цоохор"	
3.Эрнест Хэмингуэй "Өвгөн тэнгис хоёр"	
4.Ц.Түмэнбаяр "Цагаан сүүний домог"	
5.Д.Нацагдорж "Хуучин хүү"	

**7. Криллээр хөрвүүлээрэй. \ 5 оноо \**

ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

**Д.Нацагдорж минь ийм хүн байлаа.**

\ хөрөг \

Нөхөр Д.Нацагдоржийг хувьсгалаас өмнө зүс таних төдий явсаар 1921 оны долдугаар сард бие тулж танилцсан юм. Тэр үед нөхөр Д.Нацагдорж Цэргийн яамнаа бичээчийн алба хааж байв. Тэрбээр бие нарийхан, нуруу тэгш шулуун, царай цагаан, үс хөмсөг хар, цочмог харсан хүнд хялардуу юмуу гэмээр, ажиглавал тийм биш, гар хуруу тэгш, гуалиг царайлаг залуу байсан юм.

Монгол дээл голдуу өмсөх боловч мөн европ хувцас холимог хэрэглэдэг. Жишээлбэл зангиатай цамцан дээр монгол дээл өмсч явна. Савхин гутал өмсөнө. Сүүлийн үед үргэлж бүрх малгай өмсөж явах болсон. Бас цэргийн хувцас хааяа өмсөнө. Тэгж явахдаа хувцас нь цэвэр бөгөөд ямар хувцас боловч биедээ тохирсныг эдэлнэ. Ямагт дээл өмсөхийг үзэхэд үндсэрхэг үзэлтэй хүн байсан аж...

Д.Нацагдорж 1929 оноос эхлэн уран зохиолын ажилд ихээхэн шургуугаар ажиллаж ирэхдээ "Миний нутаг" гэдэг алдарт шүлэг ба бусад өгүүллэг, найруулал нилээд олныг бичсэнийг хүн бүр мэдэх тул давхарласангүй. Гагцхүү "Миний нутаг" гэдэг шүлгийг анх уран зохиолчдын санд олж авсныг ярих хэрэгтэй байна...

Нөхөр Нацагдорж зан ааш дөлгөөн даруу, үг цөөн, үерхэг нөхөрсөг, хүнийг хүндэтгэх нь дуурайлалтай, ихэрхэг бардам зан огт байхгүй, энгийн ярих буюу хурал дээр үг хэлэхийн өмнө нүдээ дээш харж бодлого тавьж байгаад ярихдаа удаан, болгоомжтой, бодлоготой оновчтой цөөхөн үгээр санал шүүмжлэлээ тавих бөгөөд ер илүү сул үг хэлэхгүй.

**1.Цогцолбор тус бүрт юуны тухай гарч байгааг зөв дарааллуулан бичээрэй.2 оноо\**

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....

**2.Эхээс Д.Нацагдоржийг үндсэрхэг үзэлтэй хүн болохыг илэрхийлсэн өгүүлбэр олж бичээрэй. \ 2 оноо \**

.....

.....

.....

**3. "Тэрбээр бие нарийхан, нуруу тэгш шулуун, царай цагаан, үс хөмсөг хар, цочмог харсан хүнд хялардуу юм уу гэмээр, ажиглавал тийм биш, гар хуруу тэгш, гуалиг царайлаг залуу байсан юм. " гэсэн хэсэгт зохиогчийн ашигласан содин содон үг хэллэг аль нь вэ? \ 2 оноо \**

.....

.....

**4. " Хөрш айлын хүү нь маргааш иржээ" гэсэн өгүүлбэрийг зөв засан найруулж бичээрэй.\2 оноо \**

.....

.....

**5.Хоол+л гэдэгтэй адил дүрэмтэй бичигддэг үг 2-ыг бичээрэй. \ 2 оноо \**

6. Зохиолын гол санааг бичээрэй. \ 5 оноо \

Зохиол	Гол санаа
1. Д.Цоодол "Харамчийнхны дууль"	
2. Л.Түдэв "Эрээн цоохор"	
3. Эрнест Хэмингуэй "Өвгөн тэнгис хоёр"	
4. Ц.Түмэнбаяр "Цагаан сүүний домог"	
5. Д.Нацагдорж "Хуучин хүү"	

7. Криллээр хөрвүүлээрэй. \ 5 оноо \

